

ТАНИЛЦУУЛГА

*Эрчим хүчний тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан. Энэхүү чиг үүргийн дагуу төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлогыг тодорхойлж ирсэн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эрчим хүчний асуудлаар оновчтой бодлого баримтлахыг заасан ба энэхүү зорилтын хүрээнд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахаар заасан байдаг.

Түүнчлэн, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрчим хүчний асуудлаар дараах бодлого зорилтуудыг тусгасан:

- эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна,
- цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна,
- төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ,
- эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ,
- Монгол Улсын хангайн бүс, баруун бүс, зүүн бүс болон говийн бүсэд нүүрс-эрчим хүчний үйлдвэр барих, төвийн бүсэд Хөшигийн хөндийд бүсийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэр болох дулааны цахилгаан станц барина,
- эрчим хүчний салбарын шинэчлэл хийж, төрөөс хэрэгжүүлэх 14 мега төслийн 4 нь эрчим хүчний төсөл байна,
- эрчим хүчний салбарт өсөлт, либералчлал хийх,
- Эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчлэхээр тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу Монгол Улс нь өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийг бий болгохын зэрэгцээ эрчим хүчний салбар өсөлт, либералчлал хийх асуудлыг тусгасан. Энэ хүрээнд эрчим хүчний томоохон төслүүдийг эхлүүлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох шаардлага бий болж байгаа ч эдгээр төслүүдийг эхлүүлэх худалдан авалт, хөрөнгө оруулалтын найдвартай эх үүсвэрийг бий болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна.

Хууль, эрх зүйн орчны хүрээнд эрчим хүчний барилга байгууламж барих, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг нь төрд хамаарах тул энэ асуудлыг Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд хэрэгжүүлэхээр байна. Түүнчлэн, төрийн худалдан авалттай холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох ёстой ч төсвийн хөрөнгийн хязгаарлагдмал нөөцөөс хамаарч эрчим хүчний хэрэгцээг төрөөс дангаар бүрэн шийдвэрлэх боломжгүй байна. Мөн эрчим хүчний эх үүсвэрийг нэг худалдан авагчийн загварт нийцүүлж сонгон шалгаруулах нь зүйтэй байна.

Нөгөө талаас тендер зарлаж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах явцад хуулийн шаардлага нь төслийн бодит хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл, барилга байгууламж, үйлдвэрлэлийн процесс нь хоорондоо шууд хамааралтай ажил, үйлчилгээ бөгөөд үүнийг багцаар нь нэг тендер болгон зарлахад энэ бүх шаардлагыг нэг дор хангаж орж ирэх гүйцэтгэгч байхгүй байна. Иймээс ч нэг багцаар тендерийг үнэлэхэд, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн хүчин чадлыг хамтад нь тооцох, гүйцэтгэгч нь санхүүжилтээ бүрэн хариуцах нөхцөлийг хуульд тусгах зайлшгүй шаардлагатай байна. Гэвч, Эрчим хүчний тухай хуулиар тусгай зөвшөөрөл авсан этгээд нь төслийг хэрэгжүүлэхээр байгаа нь бодит байдалд санхүүжилтийн дутагдал үүсгэж байна.

Эрчим хүчний төслүүд нь санхүүжилтийн хувьд өндөр өртөгтэй бөгөөд үүнийг төр дангаар санхүүжүүлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зайлшгүй шаарддаг. Гэвч, санхүүжилтийн дүнгээс хамаарч хөрөнгө оруулагч нар орж ирэхэд хүндрэлтэй томоохон төслүүдэд стратегийн хувьд ач холбогдлоос хамаарч төрөөс тодорхой хэсгийг санхүүжүүлж болдог. Энэ тохиолдолд төрийн санхүүжилттэй холбоотойгоор эрчим хүчний төслийг сонгон шалгаруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй шаардлага үүсэж байна.

Иймд, Эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний төслийг сонгон шалгаруулах нөхцөлийг тодорхой зааж, эрчим хүч нийлүүлэх үнэ, хэмжээ, эрчим хүчний эх үүсвэрийг барих, өмчлөлийг төрд шилжүүлэхтэй холбоотой харилцааг шалгуур үзүүлэлт болгон тогтоох замаар хууль, эрх зүйн өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд өвлийн их ачаалалд системийн суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, нөөц тоноглолгүй, импортын эрчим хүчний дэмжлэгтэйгээр ажиллаж байна. Тодруулбал, Монгол Улсын хэмжээнд 2024 оны гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний хэрэглээ 11,629.3 сая кВт.цаг хүрч 2023 оны гүйцэтгэлээс 653.1 сая кВт.ц буюу 6.0%-аар өссөн бөгөөд үүнээс 75.4% буюу 8,765.8 сая кВт.цаг эрчим хүчийг дотоодын эх үүсвэрүүдээс хангаж, 24.6% буюу 2,863.4 сая кВт.цаг эрчим хүчнийг импортоор авчээ.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-8 хувиар өсөж байна. Энэ хэрэглээний өсөлтийг хангах дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх, нөөц чадлын зохистой хэмжээнд (20 хувь илүү) хүргэх буюу одоо байгаа суурилагдсан хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, 2030 оны түвшинд 3750 МВт хүргэх хэрэгцээ шаардлага байна.

Эрчим хүчний салбарт 2024 онд Чойбалсангийн 50 МВт-ын дулааны цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станцын эхний 150 МВт-ын блок, Тосонцэнгэлийн дулааны цахилгаан станц эхний ээлжийн 22 МВт-ын блок, Мөрөнгийн 10 МВт-ын нарны цахилгаан станц, Эрдэнийн 30 МВт-ын нарны цахилгаан станц, Багануурын 50 МВт-ын батарей хуримтлуурыг тус тус ашиглалтад оруулсан боловч эрчим хүчний хэрэглээний өсөлтийг бүрэн хаах хангалттай түвшинд хүрээгүй хэвээр байна.

Эрчим хүчний салбарт уламжлалт эх үүсвэрийн төсөл шинээр хэрэгжүүлэхэд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай 2015 оны Парисын хэлэлцээрээс хойш Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын нүүрсний эрчим хүчний эх үүсвэрт зориулсан санхүүжилт хумигдаж эхэлсэн. Мөн 2021 оны 9 сард НҮБ-ын ерөнхий ассамблейн 76 дугаар чуулган дээр БНХАУ-ын дарга "...Хятад улс хилийн чанадад нэмж нүүрсний эрчим хүчний шинэ эх үүсвэр барихгүй..." гэсэн амлалт өгсөн нь төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос 14 хуулийн этгээд нийт 5130 МВт-ын хүчин чадалтай нүүрсээр ажилладаг эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл авсан байна. Үүнээс 2024 онд нийт 172 МВт нь ашиглалтад орж, нийт 220 МВт барилга угсралтын шатанд, нийт 4738 МВт-ын хүчин чадалтай станцын төслүүд үйл ажиллагаагаа эхлүүлээгүй тодорхойгүй байдалд байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь бүгд хэрэгжсэн тохиолдолд 2035 оны хэрэглээний өсөлтийн таацтай харьцуулахад эрчим хүчний илүүдэлд орохоор нөхцөл байдал үүсэх ба нөгөө талаас дээрх төслүүд хэрэгжихгүй тохиолдолд эрчим хүчний дутагдалд орохоор байна. Энэ нь шинээр уламжлалт эх үүсвэрийн төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулагчдын орон зайг хааж тодорхойгүй байдал үүсгэж байна.

Иймд эдгээр нүүрсээр ажиллах уламжлалт эх үүсвэрийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь санхүүгийн хувьд чадавхтай байж бодит үүрэг амлалт өгөх төслийг өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэх боломжийг нээж өгөх шаардлагатай байна.

Дээрх практик шаардлагад нийцүүлж, эрчим хүчийг либералчлах бодлогыг нэвтрүүлж, эрчим хүчний томоохон төслүүдийг яаралтай эхлүүлэх хууль эрх зүйн орчныг бий болгох шаардлагын хүрээнд Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнтэй уялдуулан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэд, аж ахуй нэгжээс цахим хэлбэрээр саналыг авахаар Эрчим хүчний яамны сайтад 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн байршуулсан бөгөөд одоогоор санал хүсэлт ирүүлээгүй байна.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар эрчим хүчийг либералчлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ба эрчим хүчний төслийг эрчим хүч нийлүүлэх үнэ, эрчим хүчний эх үүсвэрийг төрд нийлүүлэх хугацаа, нийлүүлэх хэмжээ зэргээс хамаарч сонгон шалгаруулах боломж бүрдэнэ. Түүнчлэн, төсөл сонгон шалгаруулалтыг санхүүгийн хувьд бүрэн бололцоотой оролцогчдыг үнэлэх замаар хэрэгжүүлэх тул эрчим хүчний гацсан олон төслийг хөдөлгөх бодитой нөлөөлөл үзүүлж чадна. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Засгийн газраас хэрэгжүүлэх мега төслүүдийг хөдөлгөх суурь нөхцөл болж, цаашид улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх ба үүнийг дагаа ажлыг байр нэмэгдэх, иргэдийн ая тухтай амьдрал хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаар*

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан. Энэхүү чиг үүргийн дагуу төрөөс эрчим хүчний салбарт баримтлах бодлогыг тодорхойлж ирсэн.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эрчим хүчний асуудлаар оновчтой бодлого баримтлахыг заасан ба энэхүү зорилтын хүрээнд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, хямд эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, 2020 он гэхэд нүүрс болон дотоодын бусад эх үүсвэрээр түлш, эрчим хүчний хэрэгцээг бүрэн хангахаар заасан байдаг.

Түүнчлэн, Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрчим хүчний асуудлаар дараах бодлого зорилтуудыг тусгасан:

- эдийн засгийн хөгжлийг дэмжих эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлсэн байна,
- цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангасан байна,
- төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ,
- эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ,
- Монгол Улсын хангайн бүс, баруун бүс, зүүн бүс болон говийн бүсэд нүүрс-эрчим хүчний үйлдвэр барих, төвийн бүсэд Хөшигийн хөндийд бүсийн эрчим хүчний хангамжийн эх үүсвэр болох дулааны цахилгаан станц барина,
- эрчим хүчний салбарын шинэчлэл хийж, төрөөс хэрэгжүүлэх 14 мега төслийн 4 нь эрчим хүчний төсөл байна,
- эрчим хүчний салбарт өсөлт, либералчлал хийх,
- Эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх тогтолцоог нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчлэхээр тус тус заасан.

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасны дагуу Монгол Улс нь өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засгийг бий болгохын зэрэгцээ эрчим хүчний салбар өсөлт, либералчлал хийх асуудлыг тусгасан. Энэ хүрээнд эрчим хүчний томоохон төслүүдийг эхлүүлж, эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг бий болгох шаардлага бий болж байгаа ч эдгээр төслүүдийг эхлүүлэх худалдан авалт, хөрөнгө оруулалтын найдвартай эх үүсвэрийг бий болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна.

Хууль, эрх зүйн орчны хүрээнд эрчим хүчний барилга байгууламж барих, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиг үүрэг нь төрд хамаарах тул энэ асуудлыг Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд хэрэгжүүлэхээр байна. Түүнчлэн, төрийн худалдан авалттай холбоотойгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар эрчим хүчний эх үүсвэрийг бий болгох ёстой ч төсвийн хөрөнгийн хязгаарлагдмал нөөцөөс хамаарч эрчим хүчний хэрэгцээг төрөөс дангаар бүрэн шийдвэрлэх боломжгүй байна. Мөн эрчим хүчний эх үүсвэрийг нэг худалдан авагчийн загварт нийцүүлж сонгон шалгаруулах нь зүйтэй байна.

Нөгөө талаас тендер зарлаж, төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах явцад хуулийн шаардлага нь төслийн бодит хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, эрчим хүчний эх үүсвэрийн зураг төсөл, барилга байгууламж, үйлдвэрлэлийн процесс нь хоорондоо шууд хамааралтай ажил, үйлчилгээ бөгөөд үүнийг багцаар нь нэг тендер болгон зарлахад энэ бүх шаардлагыг нэг дор хангаж орж ирэх гүйцэтгэгч байхгүй байна. Иймээс ч нэг багцаар тендерийг үнэлэхэд, гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн хүчин чадлыг хамтад нь тооцох, гүйцэтгэгч нь санхүүжилтээ бүрэн хариуцах нөхцөлийг хуульд тусгах зайлшгүй шаардлагатай байна. Гэвч, Эрчим хүчний тухай хуулиар тусгай зөвшөөрөл авсан этгээд нь төслийг хэрэгжүүлэхээр байгаа нь бодит байдалд санхүүжилтийн дутагдал үүсгэж байна.

Эрчим хүчний төслүүд нь санхүүжилтийн хувьд өндөр өртөгтэй бөгөөд үүнийг төр дангаар санхүүжүүлэх боломжгүй тул хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг зайлшгүй шаарддаг. Гэвч, санхүүжилтийн дүнгээс хамаарч хөрөнгө оруулагч нар орж ирэхэд хүндрэлтэй томоохон төслүүдэд стратегийн хувьд ач холбогдлоос хамаарч төрөөс тодорхой хэсгийг санхүүжүүлж болдог. Энэ тохиолдолд төрийн санхүүжилттэй холбоотойгоор эрчим хүчний төслийг сонгон шалгаруулах хэрэгцээ шаардлага зайлшгүй шаардлага үүсэж байна.

Иймд Эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний төслийг сонгон шалгаруулах нөхцөлийг тодорхой зааж, эрчим хүч нийлүүлэх үнэ, хэмжээ, эрчим хүчний эх үүсвэрийг барих, өмчлөлийг төрд шилжүүлэхтэй холбоотой харилцааг шалгуур үзүүлэлт болгон тогтоох замаар хууль, эрх зүйн өөрчлөлтийг хийх шаардлагатай байна.

Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд өвлийн их ачаалалд системийн суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, нөөц тоноглолгүй, импортын эрчим хүчний дэмжлэгтэйгээр ажиллаж байна. Тодруулбал, Монгол Улсын хэмжээнд 2024 оны гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний хэрэглээ 11,629.3 сая кВт.цаг хүрч 2023 оны гүйцэтгэлээс 653.1 сая кВт.ц буюу 6.0%-аар өссөн бөгөөд үүнээс 75.4% буюу 8,765.8 сая кВт.цаг эрчим хүчийг дотоодын эх үүсвэрүүдээс хангаж, 24.6% буюу 2,863.4 сая кВт.цаг эрчим хүчнийг импортоор авчээ.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ сүүлийн жилүүдэд дунджаар 7-8 хувиар өсөж байна. Энэ хэрэглээний өсөлтийг хангах дотоодын эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх, нөөц чадлын зохистой хэмжээнд (20 хувь илүү) хүргэх буюу одоо байгаа суурилагдсан хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж, 2030 оны түвшинд 3750 МВт хүргэх хэрэгцээ шаардлага байна.

Эрчим хүчний салбарт 2024 онд Чойбалсангийн 50 МВт-ын дулааны цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станцын эхний 150 МВт-ын блок, Тосонцэнгэлийн дулааны цахилгаан станц эхний ээлжийн 22 МВт-ын блок, Мөрөнгийн 10 МВт-ын нарны цахилгаан станц, Эрдэнийн 30 МВт-ын нарны цахилгаан станц, Багануурын 50 МВт-ын батарей хуримтлуурыг тус тус

ашиглалтад оруулсан боловч эрчим хүчний хэрэглээний өсөлтийг бүрэн хаах хангалттай түвшинд хүрээгүй хэвээр байна.

Эрчим хүчний салбарт уламжлалт эх үүсвэрийн төсөл шинээр хэрэгжүүлэхэд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай 2015 оны Парисын хэлэлцээрээс хойш Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын нүүрсний эрчим хүчний эх үүсвэрт зориулсан санхүүжилт хумигдаж эхэлсэн. Мөн 2021 оны 9 сард НҮБ-ын ерөнхий ассамблейн 76 дугаар чуулган дээр БНХАУ-ын дарга "...Хятад улс хилийн чанадад нэмж нүүрсний эрчим хүчний шинэ эх үүсвэр барихгүй..." гэсэн амлалт өгсөн нь төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хорооноос 14 хуулийн этгээд нийт 5130 МВт-ын хүчин чадалтай нүүрсээр ажилладаг эх үүсвэр барих тусгай зөвшөөрөл авсан байна. Үүнээс 2024 онд нийт 172 МВт нь ашиглалтад орж, нийт 220 МВт барилга угсралтын шатанд, нийт 4738 МВт-ын хүчин чадалтай станцын төслүүд үйл ажиллагаагаа эхлүүлээгүй тодорхойгүй байдалд байна. Эдгээр төсөл хөтөлбөрүүд нь бүгд хэрэгжсэн тохиолдолд 2035 оны хэрэглээний өсөлтийн таацтай харьцуулахад эрчим хүчний илүүдэлд орохоор нөхцөл байдал үүсэх ба нөгөө талаас дээрх төслүүд хэрэгжихгүй тохиолдолд эрчим хүчний дутагдалд орохоор байна. Энэ нь шинээр уламжлалт эх үүсвэрийн төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулагчдын орон зайг хааж тодорхойгүй байдал үүсгэж байна.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд эрчим хүчний төсөл сонгон шалгаруулах эрх зүйн орчныг бий болгох асуудлыг нэмэхээр тусгасан.

Эрчим хүчний хууль тогтоомжийн дагуу эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх этгээдийг өргөдөлд үндэслэн холбогдох тусгай зөвшөөрлийг олгох замаар шийдвэрлэж ирсэн. Гэвч, зарим хүсэлт гаргагчийн хувьд санхүүгийн шаардлага хангахгүйгээс өнөөдрийг хүртэл эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна. Улмаар төрөөс тодорхой хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх замаар төсөл сонгон шалгаруулах тохиолдолд тендерийн хууль эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар асуудлыг шийдвэрлэх болдог. Гэвч, бодит байдалд тендерийн хуулиар түлхүүр гардуулж, туслан гүйцэтгэгчийг хамтад нь үнэлэх зохицуулалтгүй, түүнчлэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдаж 3 жилийн нүүр үзэж байгаач өнөөдрийг хүртэл 1 ч төслийг хөдөлгөж чадаагүй буюу сонгон шалгаруулалтын процесс үе шат хэтэрхий удаан байна. Иймд, үүсээд буй нөхцөл байдал, эрчим хүчний зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний төсөл шалгаруулах асуудлыг зайлшгүй нэмэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд "эрчим хүчний төсөл", "эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгч" гэж нэр томъёог бий болгосон. Энэ нь эрчим хүчний барилгын зураг төсөл боловсруулахаас эхлээд эрчим хүчний барилга байгууламжийг барих, эрчим хүч үйлдвэрлэх асуудлаар түлхүүр гардуулах нөхцөлөөр төсөл сонгон шалгаруулах зорилгоор энэ нэр томъёог бий болгосон. Эрчим хүчний төслийн хувьд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бусад эрчим хүчний эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр түлхүүр гардуулах нөхцөлөөр буюу зураг төсөл, санхүүжилт барилгын ажлыг нэг этгээд өөрийн туслан гүйцэтгэгч нарын хамт

гүйцэтгэх, төслийн баталгааг өөрийн санхүүжилтээр хариуцахаар заасан төсөл болно.

Эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах зорилгоор эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт холбогдох сонгон шалгаруулалт зарлах, хаана уг төслийг хэрэгжүүлэх талаарх шийдвэр гаргах эрхийг олгосон.

Хуулийн энэ хэсгийн нэмэлтийн зорилго нь сонгон шалгаруулалтын харилцааг зохицуулна. Сонгон шалгаруулалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. Сонгон шалгаруулалт хийх ажлын хэсэгт тавигдах шаардлагыг хуулийн төсөл тодорхойлсон ба энэ нь тендерийн хуульд заасан үнэлгээний хороотой ижил нөхцөл, шаардлага хангасан гишүүдтэй байна. Тодруулбал, 5-аас доошгүй гишүүнтэй байх, хараат бус мэргэжлийн байх зэрэг шаардлага тавигдсан.

Энэхүү ажлын хэсэг нь сонгон шалгаруулалт зарлахад шинээр томилогддог байна. Энэ хүрээнд сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлэх, сонгон шалгаруулах эрх олгох шийдвэр гаргахад зөвлөмж өгч ажиллана. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын асуудлаар эрчим хүчний яамнаас бусад этгээдтэй харилцахгүй бөгөөд асуудлыг $\frac{3}{4}$ ирцтэйгээр олонхын саналаар шийдвэрлэдэг байхаар төсөлд тусгасан.

Ажлын хэсгийн үйл ажиллагаатай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан. Төсөл сонгон шалгаруулахад шаардлагатай баримт бичгийг тендерийн хуулийн жишгээр боловсруулахыг хуулийн төсөлд тусгасан. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд эрчим хүчний төсөл сонгон шалгаруулах эрх зүйн орчныг бий болгох асуудлыг нэмэхээр тусгасан.

Эрчим хүчний хууль тогтоомжийн дагуу эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх этгээдийг өргөдөлд үндэслэн холбогдох тусгай зөвшөөрлийг олгох замаар шийдвэрлэж ирсэн. Гэвч, зарим хүсэлт гаргагчийн хувьд санхүүгийн шаардлага хангахгүйгээс өнөөдрийг хүртэл эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна. Улмаар төрөөс тодорхой хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэх замаар төсөл сонгон шалгаруулах тохиолдолд тендерийн хууль эсхүл төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар асуудлыг шийдвэрлэх болдог. Гэвч, бодит байдалд тендерийн хуулиар түлхүүр гардуулж, туслан гүйцэтгэгчийг хамтад нь үнэлэх зохицуулалтгүй, түүнчлэн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль батлагдаж 3 жилийн нүүр үзэж байгаач өнөөдрийг хүртэл 1 ч төслийг хөдөлгөж чадаагүй буюу сонгон шалгаруулалтын процесс үе шат хэтэрхий удаан байна. Иймд, үүсээд буй нөхцөл байдал, эрчим хүчний зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн эрчим хүчний тухай хуульд эрчим хүчний төсөл шалгаруулах асуудлыг зайлшгүй нэмэх шаардлагатай байна.

Энэ хүрээнд “эрчим хүчний төсөл”, “эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгч” гэж нэр томъёог шинээр нэмэхээр тусгасан. Энэ нь эрчим хүчний барилгын зураг төсөл боловсруулахаас эхлээд эрчим хүчний барилга байгууламжийг барих, эрчим хүч үйлдвэрлэх асуудлаар түлхүүр гардуулах нөхцөлөөр төсөл сонгон

шалгаруулах зорилгоор энэ нэр томъёог бий болгосон. Эрчим хүчний төслийн хувьд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс бусад эрчим хүчний эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр түлхүүр гардуулах нөхцөлөөр буюу зураг төсөл, санхүүжилт барилгын ажлыг нэг этгээд өөрийн туслан гүйцэтгэгч нарын хамт гүйцэтгэх, төслийн баталгааг өөрийн санхүүжилтээр хариуцахаар заасан төсөл болно.

Эрчим хүчний төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах зорилгоор эрчим, хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт холбогдох сонгон шалгаруулалт зарлах, хаана уг төслийг хэрэгжүүлэх талаарх шийдвэр гаргах эрхийг олгосон.

Хуулийн энэ хэсгийн нэмэлтийн зорилго нь сонгон шалгаруулалтын харилцааг зохицуулна. Сонгон шалгаруулалтыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ. Сонгон шалгаруулалт хийх ажлын хэсэгт тавигдах шаардлагыг хуулийн төсөл тодорхойлсон ба энэ нь тендерийн хуульд заасан үнэлгээний хороотой ижил нөхцөл, шаардлага хангасан гишүүдтэй байна. Тодруулбал, 5-аас доошгүй гишүүнтэй байх, хараат бус мэргэжлийн байх зэрэг шаардлага тавигдсан.

Энэхүү ажлын хэсэг нь сонгон шалгаруулалт зарлахад шинээр томилогддог байна. Энэ хүрээнд сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үнэлэх, сонгон шалгаруулах эрх олгох шийдвэр гаргахад зөвлөмж өгч ажиллана. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын асуудлаар эрчим хүчний яамнаас бусад этгээдтэй харилцахгүй бөгөөд асуудлыг $\frac{3}{4}$ ирцтэйгээр олонхын саналаар шийдвэрлэдэг байхаар төсөлд тусгасан.

Ажлын хэсгийн гишүүдэд урамшуулал олгох асуудлыг тусгасан бөгөөд урамшууллын хэмжээг Эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Төсөл сонгон шалгаруулахад шаардлагатай баримт бичгийг тендерийн хуулийн жишгээр боловсруулахыг хуулийн төсөлд тусгасан.

Эрчим хүчний төсөл сонгон шалгаруулах гол нөхцөл нь:

- Эрчим хүчийг сүлжээнд нийлүүлэх үнэ
- Эрчим хүчний эх үүсвэрийг төрд шилжүүлэх нөхцөл, хугацаа
- Эрчим хүч нийлүүлэх хэмжээ
- Санхүүжүүлэх нөхцөл
- туслан гүйцэтгэгчийн чадавх болон туршлагын шаардлага;
- төслийн эрсдэл, хариуцлага хүлээх чадамж, баталгаа;
- төслийн үйл ажиллагаанд аардлагатай гэж үзсэн бусад нөхцөлийг тусгахыг хуулийн төсөлд тодорхойлсон.

Төсөл сонгон шалгаруулалт зарлах урилгад дараах нөхцөлийг тодорхой заахыг тусгасан:

- төсөл хэрэгжүүлэх түншлэлийн төрөл;

- санхүүжилтийн эх үүсвэрийн тодорхой хэсгийг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлэх эсэх;
- сонгон шалгаруулалт зохион байгуулах хэлийг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг гадаад хэлээр тогтоох эсэх;
- дэнчингийн хэмжээ;
- аль саналыг үнэлэх эсэх;
- гүйцэтгэлийн баталгааны хэмжээ;
- сонгон шалгаруулалтад шаардлагатай бусад нөхцөл.

Төсөл сонгон шалгаруулалтыг 1-2 үе шаттай зохион байгуулахаар заасан. 2 үе шаттай төсөл шалгаруулах бол эхний үе шатанд техникийн санал боловсруулахад шаардлагатай оролцогчийг тодорхойлно. 2 дахь үе шатанд дээрх санал ирүүлсэн оролцогчид дундаас сонгон шалгаруулт хийхээр заасан. Төсөл сонгон шалгаруулах үе шатын үндсэндээ ажлын 20 өдөр байхаар заасан.

Оролцогчийн гол нөхцөл нь төслийг санхүүжүүлэх бүрэн чадамжтай ба төслийг хэрэгжүүлэх чадамжтай ажиллах хүчийг гэрээний үндсэн дээр авч ажиллуулах боломжтой байх шаардлагатай. Энэ ч агуулгаар төсөл сонгон шалгаруулалтад тавих нэг шаардлага нь дэнчинг тавих асуудал болно. Гэрээний үүргээ биелүүлээгүй буюу төслийг хугацаанд нь эхлүүлээгүй эсхүл гүйцэтгэхгүй төслийг дэнчинг авах замаар үүргийн гүйцэтгэлийг хангуулна.

Түүнчлэн, түлхүүр гардуулах нөхцөлөөр сонгон шалгаруулалт хийхтэй холбоотойгоор туслан гүйцэтгэгчийн чадавхыг үнэлгээнд тооцох асуудлыг төсөлд тусгасан.

Энэхүү сонгон шалгаруулалтаар тодорхойлогдох төсөл хэрэгжүүлэгчтэй төрөөс төр, хувийн хэвшлийн түншлэлийн нөхцөлөөр гэрээ байгуулах асуудлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлж, шалгарсан этгээдийг тодорхойлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах эрхийг Засгийн газраас авна.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж төсөл сонгон шалгаруулах замаар эрчим хүчний эх үүсвэр барих этгээдийг тодорхойлж байгаа. Үүнтэй холбоотойгоор хувийн хэвшилтэй хамтран ажиллах хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар тусгасан.

Эрчим хүчний төслийн хувьд гол хэрэглэгч нь төр бөгөөд үүнээс ашиг олох боломжгүй тул хувийн хэвслээс түншлэлийн төрлийг сонгож орж ирэхэд хүндрэлтэй. Иймээс ч санхүүжилтийн хувьд төр өөрөө бүрэн хариуцаад явдаг төсөл тул эрчим хүчний төслийн хувьд барьж шилжүүлэх, менежмент, санхүүжилт болон барих шилжүүлэх төрлүүдийг зайлшгүй нэмэх шаардлагатай байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний талаар зохицуулсан. Энэ хүрээнд эрчим хүчний төслийн хэрэгцээ шаардлага тодорхой бөгөөд нэгэнт төсөл сонгон шалгаруулсан тохиолдолд төслийн бүрэн шинжилгээ хийгдсэн гэж үзэхээр хуулийн төсөлд тусгалаа. Төслийн бүрэн шинжилгээ нь уг төслийг хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, хэрэгжүүлэх нь үр ашиг, ач холбогдлыг эсэхийг тогтоодог.

Иймээс эрчим хүчний төслийн хувьд үр ашгийг салбарын бодлогоор тодорхойлох тул уг процессыг Эрчим хүчний тухай хуулиар хэрэгжүүлэхээр байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд түншлэлийн төслийг тодорхойлох асуудал байна. Энэ хүрээнд Засгийн газар нь холбогдох судалгаанд үндэслэн төсөл хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэдэг. Харин Засгийн газрын шийдвэрээр бус эрчим хүчний тухай хууль, Төсвийн тухай хуульд туссан төсвийн хүрээнд сонгон шалгаруулалт нэгэнт хийгдсэн бол төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэнд тооцохоор төсөлд тусгав.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37 дугаар зүйлд түншлэлийн сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах агуулга тусгагдсан. Энэ хүрээнд эрчим хүчний төсөл нь түншлэлийн тухай хуулиар бус харин эрчим хүчний тухай хуулиар сонгон шалгаруулсан тул шууд гэрээ байгуулах зохицуулалтыг хуулийн төсөл тусгасан.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг хамаарна. Энэ хүрээнд зөвхөн түншлэлийн сайд бус салбарын сайд нь хуульд заасан тохиолдолд гэрээ байгуулах боломжтой байхаар хуулийн төсөлд нэмэлт оруулсантай холбоотой хуулийн нийцлийг хангуулах өөрчлөлтийг тусгасан.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл нь хэлэлцээ хийж гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах зохицуулалт бөгөөд энэ хүрээнд эрчим хүчний төслийн хувьд хэлэлцээ хийж гэрээ байгуулах зохицуулалтыг тусгасан. Хэлэлцээ хийж гэрээ байгуулах асуудлыг эрчим хүчний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулсан салбарын яам хариуцах боломжтой байхаар тусгасны дагуу холбогдох гэрээ байгуулах зохицуулалтыг өөрчлөн найруулсан.

Өрийн удирдлагын тухай хуулийн төслийн 33 дугаар зүйл нь өрийн баталгаанд тавигдах шаардлагыг тогтоосон. Эрчим хүчний төсөл сонгон шалгаруулалтад засгийн газрын өрийн баталгааг гаргах тохиолдолд эрчим хүчний барилга байгууламжийн зураг төслийн ажил нь өөрөө ихээхэн өндөр үнэтэй төсвийг шаарддаг бөгөөд зураг төслийн ажил нь барилгын ажлын хамт хийгддэг тул Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.11-д заасан эрчим хүчний төслийг түлхүүр гардуулах нөхцөлөөр хэрэгжүүлэх гэрээнд энэ хуулийн 18.5.4-т заасан нарийвчилсан зураг төсөл батлагдсан байх шаардлага хамаарахгүй байхаар тусгасан.

Түүнчлэн, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд иргэд, аж ахуй нэгжээс цахим хэлбэрээр саналыг авахаар Эрчим хүчний яамны сайтад 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн байршуулсан бөгөөд одоогоор санал хүсэлт ирүүлээгүй байна.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар эрчим хүчийг либералчлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх ба эрчим хүчний төслийг эрчим хүч нийлүүлэх үнэ, эрчим хүчний эх үүсвэрийг төрд нийлүүлэх хугацаа, нийлүүлэх хэмжээ зэргээс хамаарч сонгон шалгаруулах боломж бүрдэнэ. Түүнчлэн, төсөл сонгон шалгаруулалтыг санхүүгийн хувьд бүрэн бололцоотой оролцогчдыг үнэлэх замаар хэрэгжүүлэх тул эрчим хүчний гацсан олон төслийг хөдөлгөх бодитой нөлөөлөл үзүүлнэ.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Засгийн газраас хэрэгжүүлэх мега төслүүдийг хөдөлгөх суурь нөхцөл болж, цаашид улс орны нийгэм, эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх ба үүнийг дагаа ажлыг байр нэмэгдэх, иргэдийн ая тухтай амьдрал хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

---o0o---